

Геологийн алба үүсэж хөгжсөний 76 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохиогдсон “улаанбаатарын дүүргийн геологийн сонгомол бүтцүүдийн тогтоц” сэдэвт экскурс, геологийн ажил мэргэжлийн уралдааны товч

/2015.10.13-14-ны өдрүүдэд/

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа судалгааны ажлууд нь ихэнхийг аж ахуйн нэгжүүд гүйцэтгэдэг бөгөөд түүнд ажиллаж байгаа боловсон хүчний ур чадвараас ажлын чанар их хамаардаг.

Иймээс УУЯ, АМГ-ын ГА-наас ажлын чанар, хэтийн төлөв, цаашдын ажлын зорилго, үр өгөөмжийг дээшлүүлэх зорилгоор 2010 оноос хойш онолын болон үйлдвэрлэлийн сургалт семинарыг жилд нэг удаа явуулж хэвшүүлээд байна.

Энэ удаагийн сургалтыг 10-р сарын 13-ны өдөр хээрийн экскурс байдлаар Улаанбаатар хотын орчмын геологийн онцлог тогтоц бүхий хэсгүүдэд хийсэн. Сургалтыг дараахь сэдвээр хийсэн. Үүнд:

Чулуутын Ам, Төр Хурахын дүүргийн структур /Д.Чулуун, С.Хишигсүрэн/

Арлан нумын Шохойн Цагаан Булагийн геологийн онцлог /Г.Ээнжин/

Налайх-Тэрэлжийн геологийн тогтоц /Г.Ээнжин/

Эрдэнийн дүүргийн геологийн тогтоц /Т.Оюунчимэг/

Сургалтанд 115 орчим геологич, оюутнууд оролцсон.



Зураг №1 Хээрийн экскурсын үеэрх танилцуулга хийгдэж байгаа нь



Зураг №2. Доктор Х.Оюунчимэгийн танилцуулгын үед

10-р сарын 14-ны өдөр Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50 000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил гүйцэтгэж буй компаниудын дунд ажил мэргэжлийн тэмцээнийг УУЯ, АМГ, РЗ, МГХ, МСК-оос зохион байгууллаа.

Тус тэмцээнд “Геологийн судалгааны төв” /ТӨҮГ/-аас 2 баг, “Гурван талст” ХХК-иас 2 баг, “Найман бат” ХХК, “Монголын зүрх сэтгэл” ХХК, “Жинст уул” ХХК, “Эрээн чулуу” ХХК, “Судалт мана ХХК, “Жи Жи Ай Эс ХХК”, Гурван талст ХХК, ШУТИС-ийн ГУУГТС-ийн тус бүр 1 багууд нийт 11 баг геологийн зураглалын төрлөөр оролцсон.



Зураг №3. Ажил мэргэжлийн тэмцээн эхлэхийн өмнө

Тэмцээнийг дүгнэхдээ геологийн анхдагч баримт бүрдлийн чанар, бүрэн гүйцэт бүрдүүлсэн байдал зэргийг харгалзан дүгнэсэн бөгөөд Тэмцээний нийт нийлбэр дүнгээр :

- Тэргүүн байранд “Судалт мана” ХХК орж цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
 - 2-р байранд “Жи Жи Ай Эс” ХХК орж мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
 - 3-р байрыг “Геологийн судалгааны төв” /ТӨҮГ/-ын Б.Дамдинжав ахлагчтай баг хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,
 - Тусгай байранд “Гурван талст” ХХК-ын П.Ариунболд ахлагчтай баг орж мөнгөн шагнал тус тус хүртсэн
- Уг тэмцээнд орсон геологичдоос “Шилдэг залуу геологич”, “Өсөх ирээдүйтэй залуу геологич”, “Ирээдүй залуу халаа” гэсэн номинацид нэр дэвшүүлэн шалгаруулж шагнал гардуулсан.



Зураг №4. Оролцсон багууд дурсгалын зураг авахуулав

Мэргэжлийн тэмцээний үеэр мөн хэрэгжиж буй төслүүд, компаниудын танилцуулга, үйл ажиллагааны чиглэлээр танилцуулгууд явагдаж тэмцээн үр дүнтэй боллоо.